



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот

“Ард даатгал” ХХК-д хувьцаа эзэмшигчдийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ард даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигч “Интер групп интернэйшнл” ХХК-ийн эзэмшлийн 907 499 613.07 /есөн зуун долоон сая дөрвөн зуун ерэн есөн мянга зургаан зуун арван гурван төгрөг долоон мөнгө/ төгрөгийн бүгд 492 537 /дөрвөн зуун ерэн хоёр мянга таван зуун гучин долоо/ ширхэг хувьцааг хувьцаа солилцох гэрээний үндсэн дээр “Ард санхүүгийн нэгдэл” ХХК-д, хувьцаа эзэмшигч Ц.Тогтохбаярын эзэмшлийн 742 159 155.85 /долоон зуун дөчин хоёр сая нэг зуун тавин есөн мянга нэг зуун тавин таван төгрөг наян таван мөнгө/ төгрөгийн бүгд 402 800 /дөрвөн зуун хоёр мянга найман зуу/ ширхэг хувьцааг хувьцаа болон дагалдах эрхийг шилжүүлэх гэрээний үндсэн дээр Ц.Тогтохбаярын өөрийн үүсгэн байгуулсан “Блюпланэт” ХХК-д, хувьцаа эзэмшигч Б.Мөнхөөгийн эзэмшлийн 128 975 027.08 /нэг зуун хорин найман сая есөн зуун далан таван мянга хорин долоон төгрөг найман мөнгө/ төгрөгийн бүгд 70 000 /далан мянга/ ширхэг хувьцааг хувьцаа болон дагалдах эрхийг шилжүүлэх гэрээний үндсэн дээр Б.Мөнхөөгийн өөрийн үүсгэн байгуулсан “Энержи интернэшнл капитал” ХХК-д тус тус шилжүүлэхийг зөвшөөрч, компанийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	“Интер групп интернэйшнл” ХХК	907 499 613.07	-907 499 613.07		
2	“Ард санхүүгийн нэгдэл” ХХК		+907 499 613.07	907 499 613.07	33.00
3	Вэнчэрс Уан Б.В	613 552 628.85		613 552 628.85	22.31
4	Ц.Тогтохбаяр	742 159 155.85	-742 159 155.85		
5	“Блюпланэт” ХХК		+742 159 155.85	742 159 155.85	26.99
6	Д.Чулуунцэцэг	302 538 563.53		302 538 563.53	11.00
7	Б.Мөнхөө	128 975 027.08	-128 975 027.08		

000330

8	“Энержи интернэшнл капитал” ХХК		+128 975 027.08	128 975 027.08	4.69
9	Н.Эрдэнэтулга	55 275 011.62		55 275 011.62	2.01
	Нийт	2 750 000 000.00		2 750 000 000.00	100.0

2. Хувь нийлүүлэгчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2014 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Ард даатгал” ХХК /Д.Чулуунцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН